

Вакцины 3 дахь тунд хамруулахын тулд гадаадын оронд вакцинд хамрагдсан иргэдийн вакцинжуулалтын мэдээллийг бүртгэх тухай

□ Агуулга

- Хилийн чанадад корона-19 вакцинд хамрагдсан боловч хилээр нэвтрэхдээ хорио цээрийн тусгаарлалтаас чөлөөлөх бичиг авж чадаагүй гадаадын иргэн*нь Солонгост вакцины 3 дахь тунгаа хийлгэх боломжтой.
 - * (Хилийн чанадад вакцинд хамрагдсан гадаадын иргэн) хорио цээрийн тусгаарлалтаас чөлөөлсөн бичигтэй бол гадаадад вакцинд хамрагдсан эсэх тухай мэдээллийг бүртгэнэ. ('21.10.7.~)
- Солонгос дахь АНУ-ын цэргийн баазд**вакцинд хамрагдсан боловч тэтгэвэрт гарах мэт шалтгаанаар харьяалал өөрчлөгдөн вакцинжуулалтын мэдээллээ бүртгүүлэх боломжгүй байсан хүмүүс ч вакцинжуулалтын мэдээллээ бүртгүүлэх боломжтой.
 - ** (Солонгос дахь АНУ-ын цэргийн баазд вакцинжуулалтад хамрагдагч) Солонгос дахь АНУ-ын цэргийн баазд вакцинжуулалтын талаарх мэдээллээ бүртгүүлсний дараа вакцинжуулалтын гэрчилгээ авна.

□ Зорилго

- Энэ удаагийн зохицуулалтаар дамжуулан вакцины 1·2-р тунгаа хийлгэсэн мэдээллээ бүртгүүлсэн гадаадын иргэд корона-19 вакцины хилийн чанад дахь вакцинжуулалтын гэрчилгээ (COOVорood) олгох, вакцины 3 дахь тунгаа хийлгэх болон хорио цээрийн нэвтрэх журамд хамрагдана.

□ Бүртгэлд хамрагдах вакцин

- Вакцинжуулалтын мэдээллийн бүртгэлд *зөвхөн WHO зөвшөөрөгдсөн вакцин хамаарна.
 - * Файзер, Янсен, Модерна, Астра зенека, Covishield (AZ-Энэтхэгийн цусны ийлдэс судлалын хүрээлэн), Синофарм(Бээжин), Sinovac, хамрын вакцин
- Хорио цээрийн журмын дагуу тусгаарлалтаас чөлөөлөгдөх бичиггүй гадаадын иргэн 3 дахь тундаа хамрагдвал дотоодод вакцинжуулалтад хамрагдсан бүртгэл хийнэ.
- Хилээр дахин нэвтрэн орж ирэх болон батлагдсан өвчтөнтэй ойрын хавьталд орсон тохиолдолд хорио цээрийн тусгаарлалтаас чөлөөлөх

□ Хэрхэн бүртгүүлэх вэ?

- Гадаадын оронд хамрагдсан вакцинжуулалтын мэдээллээ бүртгэлд хамруулахыг хүссэн гадаадын иргэн нь хувийн бичиг баримт болон гадаадад вакцинд хамрагдсан гэрчилгээний хамт эрүүл мэндийн төвд очиж бүртгүүлнэ.

<Энэхүү орчуулгыг Данүри төв 1577-1366 хийсэн болно>